



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон,
Сүхбаатарын талбай 6, Утас: 26-70-16. Факс: 32-70-16.
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2018.01.30 № 07

Асуулт тавих тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар танд дараах асуултыг тавьж байна.

“Хувь хүний орлогын албан татварын тухай” Монгол улсын хуулийн 24.6 дах зүйлд “Албан татвар төлөгчийн төрсөн буюу үрчилсэн хүүхэд гадаад, дотоодын их, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль, коллежид элсэн суралцаж байгаа бол түүний сургалтад төлсөн, баримтаар нотлогдож байгаа төлбөрийн хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ.” гэж заасан.

Гэтэл дээрх хуулийн заалт практик дээр зөв хэрэглэгдэхгүй байна гэсэн гомдол иргэдээс их ирж байна. Тодруулбал, хүүхдийнхээ сургалтын төлбөрт төлсөн төлбөрийн хэмжээгээр төлсөн албан татвараас нь хасч, хөнгөлөлт үзүүлэх ёстой байтал татвар ногдох орлогоос нь хасч, орлогын хөнгөлөлт үзүүлдэг байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд “Албан татвараас чөлөөлөх орлого” ба “Албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх” гэсэн 2 ойлголтыг тус тусад нь салгаж, хуулийн 16 дугаар зүйл болон 24 дүгээр зүйлээр тус тусад нь зохицуулахаар тусгагдсан.


ТЕГ-ын даргын 2011 оны 12 дугаар сарын 08-ний өдрийн 728 дугаар тушаалын Нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хувь хүний орлогын албан татварын тайлан”-ийн маягтын 62 дугаар мөрөнд “Татвар ногдох орлогоос чөлөөлөгдөх орлогын дүн” гэж хуулийн 16 дугаар зүйлд заасан орлогуудыг тусгайлан зааж өгсөн мөртлөө түүн дотроо Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дах зүйлд заасан “албан татвараас чөлөөлөгдөх ёстой сургалтын төлбөр”-ийг оруулсан нь будилааны эх үүсвэр болж байна гэж иргэд гомдол мэдүүлж байна. Иргэдийг дээр дурдсан маягтын дагуу тайлангаа гаргахыг шаардаж ирсэн тул иргэдийн хувьд хүүхдийнхээ сургалтын төлбөрт төлсөн мөнгөний хэмжээгээр албан татварын хөнгөлөлт хуулийн дагуу эдлэх боломжгүй болгож байгаа юм байна.

Иймд иргэдийн ирүүлж буй дээрх гомдлын талаар хариулт өгнө үү.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан 14 хоногийн хугацаанд бичгээр ирүүлж, улмаар Байнгын хорооны хуралдаанд сонсгохыг таниас хүсье.

Хувийг: Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



О.БАТНАСАН

0000000005